

## УРАН ЗОХИОЛЫН ОРЧУУЛГАД СОЁЛ, СЭТГЭЛГЭЭНИЙ ОНЦЛОГИЙГ ИЛЭРХИЙЛЭХ НЬ

( Харүки Мүраками “1Q84” зохиолын жишээн дээр )

Л.Сүрэнбаатар<sup>65</sup>

Б.Хишигдэлгэр<sup>66</sup>

**Abstract:** *The purpose of the research study is to determine the characteristics of a nation's culture and mentality on the basis of a sematic study of how literary translations express languages, culture, personal outlook on life, aesthetics, and moral and inner values. The novelty of the research lies in the semantic interpretation using original novel and the translation to explain how Haruki Murakami's worldview, his writing style, the depth of the tone that reaches many hearts of the readers, and the emotional tone and the artistic expression of the translator altogether establish a harmony in depth of meaning of literature.*

**Түлхүүр үг:** *утга, дүрслэл, үндэстний сэтгэлгээ, соёл, дотоод ертөнц*

### Оршил

Энэхүү судалгааны ажлын зорилго нь уран зохиолын орчуулгад хэл соёл, хувь хүний ертөнцийг үзэх үзэл, гоо зүйн болоод ёс суртахууны үнэлэмж, дотоод сэтгэл, мөн чанар зэргийг хэрхэн илэрхийлсэн тухай утга зүйн судалгааны үндсэн дээр тухайн үндэстний соёл, сэтгэлгээний онцлог шинж чанарыг тодорхойлох явдал юм. Судалгааны ажлын шинэлэг тал, ач холбогдол нь Харүки Мүракамигийн өөрийн бүтээлээр дамжуулах ертөнцийг үзэх үзэл, бичлэг найруулгын арга барил, өнгө аясын гүнд нэвтрэн, хүний сэтгэл хөдөлгөх өнгө аяс, уран сайхны амт шимтийг орчуулагч хэрхэн илэрхийлсэн зэргийг эх ба орчуулгын жишээн дээр утга зүйн талаас авч үзэн тайлбарлах оролдлого хийсэнд оршино.

Японы постмодерн уран зохиолын гол төлөөлөгч болох Харүки Мүракамигийн “Норвегийн шугуй ノルウェイの森”, “Хонинд учирсан адал явдал 羊をめぐる冒険” зэрэг олон арван алдартай бүтээлүүдээс манай уншигч олны хүртээл болсны нэг нь орчуулагч О.Жаргалсайханы орчуулсан “1Q84” цуврал романы нэгдүгээр дэвтэр юм. Хүний дотоод мөн чанар, сэтгэлгээ, соёлын онцлогийг хэрхэн илэрхийлсэн тухай утга зүйн судалгаанд аливаа улсын хэл нь соёлыг тээн түгээж, хэлний аливаа махбод нь соёлын тодорхой агуулгыг хадгалж байдаг бол, сэтгэлгээ нь хэлэнд тусч, хэлээр дамжин илэрдэг гэсэн ойлголтыг энэхүү орчуулгын бүтээлийн тодорхой жишээн дээр тайлбарлахыг зорьсон болно.

---

<sup>65</sup> Доктор /Ph.D/, Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль, Гадаад хэлний тэнхим

<sup>66</sup> Доктор /Ph.D/, МУИС, ШУС, Хүмүүнлэгийн Ухааны Салбарын Ази судлалын тэнхим

Ингэхдээ уг орчуулгын бүтээлд уран яруу хэрэглүүр, метафор 隱喩 (いんゆ), зүйрлэл 直喩 (ちよくゆ), төлөөлөл 換喩 (かんゆ), хэтрүүлэл 誇張法 (こちようほう), багасгал 緩叙法 (かんじょほう), эсрэг хэлхэц くびき法, хүншүүлэл 擬人法 (ぎじんほう), ёгтлол 提喩 (ていゆ), тойруулал 婉曲法 (えんきよくほう), чимэг үг 曲言法 (きよくげんほう) зэргийг хэрхэн буулгасан болохыг авч үзье.

Харүки Мүраками зохиолчийн онцлог нь энгийн хялбар үг хэллэгээр нарийн төвөгтэй утга санааг илэрхийлэх арга барилаар зохиол бичдэг бөгөөд зохиомж дүрслэл нь нэн өвөрмөц байдаг. Зохиолч энэхүү зохиолын санааг 1995 онд болсон бодит явдлаас сэдэвлэсэн бөгөөд нийслэл Тоокёо хотын метронд хорт хийгээр олон хүнийг хордуулж, амь насыг нь бүрэлгэсэн аймшигт хэргийн түүхээс санаа авчээ. “1Q84” зохиолын “Q” үсэг нь “кюү” буюу 9-ийн тоог илэрхийлсэн нь зохиолчийн нэгэн үгэн дүрслэл юм. Уг романд орчин үеийн залуучуудын амьдралын хэв маяг, дотоод ертөнцийн илрэл, хайр сэтгэлийн тухай өгүүлнэ. Зохиолын гол дүр болох Тэнго, Аомамэ хэмээх охин, хүү хоёр 10 настай бага сургуулийн сурагч байх үеэс өөр өөрийн замаар салан одно. Тэд хоорондоо огт холбоо харилцаагүй байсаар хоёул “1Q84 он” хэмээх өөр ертөнцийн элдэв сонин адал явдалтай учирна. Тэд 1984 оны 12 сард 20 жилийн дараа уулзалдан эх дэлхийд буцаж ирснээр зохиол төгсөнө.

Зохиолын агуулгыг тоймлон өгүүлбэл, спортын дасгалжуулагч багш Аомамэ гэр бүлийн хүчирхийлэл үйлдлэгч эрчүүдийг устгах санал хүлээн авна. Тэрээр нас барсан хүнийг зүрхний дутагдалд орсон мэтээр харагдуулдаг, хүний эмзэг цэг буюу үхлийн газар нь зүүгээр хатгаж үгүй хийх чадвартай нэгэн аж. 1984 оны 4 сард ээлжит захиалгат ажлаа дуусгаад тэрээр өөр ертөнц буюу “1Q84 он”-д амьдарч буйгаа мэдэрнэ.

Нөгөөтээгүүр бага сургуулийн тооны багш Тэнго үргэлжилсэн үгийн зохиолч болохоор шийдэж, утга зохиолын шинэ уран бүтээлийн шагналын төлөө зохиол бүтээлээ цөхрөлтгүй бичнэ. Тэрээр сэтгүүлийн эрхлэгч Комацүтай танилцан, шинэ уран бүтээл сонгон шалгаруулах ажлын санал хүлээн авна. Тэнго сэтгүүлийн зөвлөлд ирсэн бүтээл дотроос Фүкаэри охины бичсэн “Агаарын авгалдай” хэмээх зохиолыг шагналд нэр дэвшүүлэх талаар Комацүд санал болгоно. Комацүгийн зөвлөснөөр Тэнго уг зохиолыг сайжруулан бичиж дуусган, уг бүтээл шинэ уран бүтээлийн шагнал хүртэж, зах зээлд их хэмжээгээр амжилттай борлогдоно. Гэвч Тэнго өөрийн эргэн тойрон, ертөнцийн юмс үзэгдэл өөр болж “Агаарын авгалдайн” ертөнц мэт болж буйг мэдэрнэ.

Ийнхүү зохиолд үйл явдалууд өрнөх ба хүний дотоод мөн чанар, сэтгэлгээ, үндэсний соёл зан заншил, хувь хүний нийтлэг болоод онцгой шинж чанар зэргийг зохиолч хэрхэн шигтгээ болгон өгүүлсэн нь орчуулгад ямархуу байдлаар буусан талаар энд дурьдах хэрэгтэй болов уу. Ялангуяа тухайн улс үндэстний соёл сэтгэлгээг орчуулгын бүтээлээр аливаа өөр үндэстэн, энгийн уншигчдад хэрхэн ойлгомжтой утга санаа нэгдмэл байдлаар хүргэх нь нэн чухал юм. Иймд

орчуулгын бүтээлд үндэсний соёл сэтгэлгээг хэрхэн илэрхийлснийг тодорхой жишээн дээр тулгуурлан утга зүйн талаас нь тайлбарлахыг оролдсон болно.

**Уран зохиолын орчуулгад соёл, сэтгэлгээний онцлогийг илэрхийлэх нь**

Зохиолын тодорхой хэсгүүдэд Япон хүний дотоод мөн чанар, биеэ авч яваа байдал, зан төлөв, үзэл бодол, нийгмийн байр суурь зэргийг тодорхой дүрслэн харуулсан бөгөөд тухайн үндэстний хэл соёл, сэтгэлгээг хэрхэн илэрхийлсэн байдлыг утга зүйн талаас нь дараах жишээнүүд дээр авч үзэж болох юм. Үүнд:

- ① タマルが青豆を玄関で迎えた。暗い色合いの夏物のスーツを着て白いシャツに無地のネクタイをしめていた。そして汗ひとつかいていない彼のような大柄な男がどんな暑い日にも汗をかかないというのは青豆に常に大きな不思議だった。

**Тамарү үүдний хонгилд Аомамэг угтлаа. Зуны хар бараан хослол өмсөж, цагаан цамцан дээр зангиа зүүсэн бөгөөд хөлс ер үзэгдсэнгүй. Түүн шиг лагс зузаан биетэй эр ямар ч халуун өдөр хөлөрдөггүй нь Аомамэд их хачирхалтай санагддаг.**

Энд “үүдний хонгил” гэдэг ойлголт бидэнд гадаа орц гэсэн утгаар буух болов уу. Япон хүмүүсийн орон сууцны зохион байгуулалт, орон зайн ойлголтоор “玄関” нь үүдний хонгил гэхээс илүү өрөө коридор гэсэн утга юм. Зочиндоо хүндэтгэл үзүүлэн үүднээс хүлээн авах гэдэг нь нийтлэг хүндлэл учраас үүдний хонгил гэдэг үгийн сонголт хэр оновчтой вэ гэсэн шүүмжлэл байж болох юм. Мөн хар халуунд бараан хослол өмссөн лагс биетэй эр огт хөлсгүй байх гэсэн ойлголт хачирхалтай санагдах нь хэвийн зүйл мэт байж болно. Гэхдээ энэ нь улирал, цаг агаарын онцлог, тухайн орны уур амьсгалд дасан зохицсон хүний бие организмын онцлог зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалсан байж болох хэдий ч зохиолын дүр, гайхан хачирхах байдал нь оньсого мэт санагдавч хөлс багатай хүн гэж хувь хүний онцлогийг харуулсан байж болох талтай. Нөгөө талаас хар бараан өнгөтэй зуны хослол гэж буй ч түүний материал нь биед хөнгөн салхи сайн нэвтрүүлдэг чанартай гэсэн цаад логик санааг ч энд орхигдуулах боломжгүй юм.

Энэ хэсэгт хүний дасан зохицох чадвар, хувь хүний бие организмын онцлог зэргийг зохиолч харуулахыг эрмэлзсэн нь тодорхой юм. Япон хүний сэтгэхүйд оршдог халуун өдөр ханцуйтай хувцас өмсөх нь сэрүүхэн байдаг гэсэн ойлголт ч үүнтэй холбоотой гэж үзэж болно.

- ② 彼女はジュンコ・シマダのグリーンの薄いウールのスーツの上に、ベージュのスプリング・コートを着て、黒い革のショルダーバッグをかけていた。肩までの髪はきれいにカットされ、よく手入れされている。装身具に類するものは一切つけていない。

**Бүсгүй “Жүнко Шимада” фирмийн саарал ноосон даавуун хослол дээр хавар намрын цайвар цув өмсөж, арьсан цүнх барьжээ. Дал мөр хүртлээ тайрсан үсээ нилээд янзалсан бололтой харагдана. Элдэв янз чимэг зүүлт ер хэрэглээгүй аж.**

Ажил хэрэгч эмэгтэйн дүрслэл нь даруухан, илүү дутуу гоёл чимэглэл зүүгээгүй гэдэг ойлголт сэтгэлгээ орчин үед олон талтай болж ирсэн. Ажлын хэрэгцээ шаардлага дотоод дүрэм журмаар илт нүдэнд тусаж хүний анхаарал татах байдлаар гоёлын зүүлт, үнэт эдлэл хэрэглэх боломжгүй байдал их байдаг. Япон ажил хэрэгч эмэгтэй бүхэн даруухан хувцаслаж, элдэв чимэг зүүдэггүй гэсэн ойлголтыг уншигчдад хүргэх гэхээс илүүтэй чанартай хувцас нь ажил хэрэгч эмэгтэйг төлөөлөх болсон гэдгийг энд харуулах нь чухал байсан байж болох юм.

Хавар намрын цайвар цув, өвлийн булган шуба гэх мэт хувцас бүрийг улирлын зориулалтаар нь тодорхойлох нь 4 улирлын эрс тэс уур амьсгалд амьдардаг бидэнд ойр дөт байгаа болов уу. Үүнээс гадна, гадаад дүр төрхөөр зогсохгүй хүний дотоод мөн чанар, сэтгэлгээний ялгааг дараах эх ба орчуулгын жишээ дээр авч үзье.

- ③ 中年の運転手は、まるで 舳先<sup>へさき</sup>に立って 不吉<sup>ふきつ</sup>な 潮目<sup>しおめ</sup>を読む 老練<sup>ろうれん</sup>な漁師  
のように、前方に途切れなく並んだ車の列をただ口を閉ざして見つめて  
いた。

**Хижээл насны жолооч эр амаа жимийн, өчүүхэн ч зай завсаргүй эгнэн зогсоод машины цувааг завиныхаа хамар дээр зогсоод тэнгисийн түрлэгийг бүтэл муутай шинжтэй нүд салгалгүй ширтэх чадмаг загасчин мэт ажиглаж суулаа.**

Энэ хэсэгт япон хүний тэсвэр тэвчээр, аливаа юманд хүлээцтэй байдал зэргийг илэрхийлэхээс гадна өнөөгийн нийгэмд хүний хүчин зүйлээс үл хамаарах давагдашгүй нөхцөл байдал үүсэж буйг харуулжээ. Монгол хүн моринд эрэмгий гэдэгтэй адил далайг шүтэж, арал дээр амьдрах ард түмний илэрхийлэл яах аргагүй “чадмаг загасчин” байх болов уу.

Мөн аливаа зүйлийг тойруулан, эерүүлэн зөөлрүүлж хэлдэг, эсвэл өөрийн хэлэх үгээ чөлөөтэй шулуун хэлэх, шүүмжлэх зэрэг нь хэн нэгэнд эмээглэл төрүүлнэ хэмээн аль болохоор зайлсхийдэг, юмыг яг байгаагаар нь шууд хэлдэггүй үндэстний зан араншинг дараах жишээн дээр жолоочийн дүрээр илэрхийлжээ. Энэ нь дотоод сэтгэл, бодол санаагаа тэр болгон ил шулуун илэрхийлдэггүй япон хүний нийтлэг мөн чанар, аливаа зүйлд хандах үнэлэмж нь тодорхой шууд бус тойруулсан байдаг харилцааны соёл, сэтгэлгээний нэг илрэл гэж үзэж болох юм.

- ④ 運転手の話し方には何かしらひっかかるものがあった。常にものごとを  
ひとつ言い残したようなしゃべり方をする。たとえば(あくまでたとえ  
ばだが)トヨタの車が 遮音<sup>しゃおん</sup>に関しては文句のつけようがないが、他の  
何かに関しては問題がある、というような。

**Жолоочийн ярианд яагаад ч юм татагдах зүйл байлаа. Их л чухал зүйл хэлэхгүй үлдээчихсэн мэт өнгөөр ярих ажээ. Жишээлбэл Тоёотагийн өсгөгч төхөөрөмжийн тухайд үнэндээ өө хэлэхээргүй ч өөр ямар нэг зүйлд асуудал байж л байдаг гэдэгчлэн.**

Энэ хэсэгт ч бас япон хүний нийтлэг шинж болох зожигдуу ганцаардмал, бусадтай хувийн амьдрал, зовлон жаргалаа тэр болгон ярьдаггүй зэрэг дотоод мөн чанарыг утга зохиолын сэтгүүлийн редактор Комацүгийн дүрээр илэрхийлжээ. Гэхдээ орчин үед хувь хүний амьдрал, мэдээлэл тэр болгон ил тод байх нь ёс зүй, хүний эрх талаасаа зохисгүй гэсэн ойлголт нийтлэг болж буй тул зөвхөн япон хүн л хувийн амьдралынхаа тухай бусдад ярьдаггүй гэж тодорхойлох нь учир дутагдалтай юм. Монголчуудын хувьд ч олон жил хамт ажилласан, ойр дотно байсан хүмүүс бие биедээ хувийн амьдралаа тэр болгон ярьдаггүй тохиолдол байдаг. Харин энэхүү хүмүүс хоорондын харилцааны халуун дулаан бус уур амьсгал япончуудын дунд нийтлэг ажиглагддаг байж болохыг үгүйсгэх аргагүй юм.

- ⑤ 小松は天吾より十六歳年上で、四十五歳になる。文芸誌の編集一筋でやってきて、業界ではやり手としてそれなりに名を知られているが、その私生活について知る人はいない。仕事上のつきあいはあっても、誰とも個人的な話をしないからだ。彼はどこで生まれて、どこで育ち、今どこに住んでいるのか、天吾は何ひとつ知らなかった。長く話をしても、そんな話題は一切出てこない。

**Комацү Тэнгогоос 18 насаар ах 45 тай. Утга зохиолын сэтгүүлийн газарт ажилладаг. Утга зохиолын ертөнцөд чадварлаг нэгэн хэмээгдэн бас гайгүй ч нэр хүндтэй бөгөөд харин түүний хувийн амьдралын талаар мэдэх хүн үгүй. Ажил хэргийн нөхөрлөл тогтоох хэдий ч хувийн амьдралынхаа тухай ам нээдэггүй. Тэрээр хаана төрж өссөн, хаана боловсрол эзэмшсэн, хаана амьдардаг тухай Тэнго ер мэдэхгүй. Урт удаан ярилцаж суувч тэр тухайд ер ам нээхгүй.**

Аливаа нийгэмд хувь хүний нэр төр, өөрийн болоод гэр бүлийн гишүүдийн ажил мэргэжил, амьдралын түвшин, эрүүл мэндийн байдал зэргээс нь болж ялгаварлан үзэх, гадуурхах, доог тохуу хийх үзэгдэл ямагт байсаар байгааг дараах хэсэгт харуулжээ. Японы нийгмийн талаарх ойлголт багатай манай уншигчдын хувьд NHK телевизийн хураамжийг телевизийн ажилтан айл өрхүүдээр явж хураадаг нь тэгтлээ хүн доог тохуу хийгээд байх хэмжээний ойлголт төрүүлэхгүй байж магадгүй.

Түүнчлэн японы нийгэмд тухайн хүний гадаад дүр төрх, бусдаас онцгой шинж болон сул талуудыг нэрэнд нь орж буй ханзны утгатай нь холбон доог тохуу хийх, нэр хоч өгөх үзэгдэл хүүхэд залуусын дунд түгээмэл байдаг. Үүний жишээг зохиолын гол дүр Аоэмамэ “хөх буурцаг” ( шош) гэсэн нэрээр төлөөлүүлэн шош буурцагны нэр төрлүүдээс жишээ татан тухайн хүний нүүр царай дүр төрхтэй холбон доог тохуу хийх байдлаар дүрсэлжээ.

- ⑥ 小学校三年生のときに、彼の父親が NHK の集金人をしていることは、クラスでも周知の事実となった。たぶん 父親と集金に歩いているところを見られたのだろう。…… 誰かに目撃されるのは当然の成り行きである (父親の陰に隠れるには、彼はもう大きくなりすぎていた)

そして、彼は「NHK」というあだ名で呼ばれることになった。ホワイトカラーの中産階級子供たちが集まっている社会では、一種の「異人種」にならざるを得なかった。

**Бага сургуулийн 3-р ангид байхад нь Тэнгогийн эцэг NHK телевизийн мөнгө хураагч хийдэг болох нь хавь ойрынхонд нь, ангийн найз нөхдөд нь ил боллоо. Магадгүй эцэгтэйгээ явж байхыг хэн нэгэн харсан биз. Хэн нэгэнд харагдах нь мэдээж хэрэг (эцгийнхээ араар нуугдавч тэр нэгэнт том болсон болохоор) ...**

**Түүнээс хойш түүнийг NHK гэж хочлох болов. Хар цагаан дундаж давхаргын хүүхдүүд цугларсан газар тэрээр нэг төрлийн “харь хүн” болохоос аргагүйд хүрчээ.**

- ⑦ そのたびに「いいえ、枝豆、空豆ではなく、青豆です。まあ、似たようなものですが」と訂正した。

**Тэр бүр “үгүй ээ Эдамамэ, Сорамамэ биш Аомамэ, үсэг нь адилхан болохоор” гэж залруулна.**

Япон хүний соёл сэтгэлгээний онцлог байдлыг илтгэх орчуулгын дараах жишээнээс үзвэл хий хоосон чанар зэргийг “будааны зэлгий зутан” гэсэн ойлголттой адилтган зүйрлэсэн байна. Тэр болгон будааны зутан хоол хүнсэндээ хэрэглэдэггүй бидний хувьд энэ зүйрлэл адилтгал тэр болгон санаанд бууж ирэхгүй байх талтай.

Дараагийн жишээ ч мөн ялгаагүй хоол хүнстэй холбоотой соёл сэтгэлгээг хөнджээ. Энд “...уран бүтээлийн ертөнцөд 20 гаруй жил ажиллалаа” гэсэн утгаар “хоол ご飯 (агшаасан будаа гэсэн утга илэрхийлж болно) хороолоо” гэсэн дүрслэлд хоол гэдэг нь “будаа” бол гол хоол хүнс гэсэн далд утга байж болох юм.

- ⑧ 世界はゆるい粥（かゆ）のようにどろどろとして骨格を持たず、捉えどころがない。それは脳内に記憶を形成することなく、窓の外を過ぎ去っていく。

**Хорвоо ертөнц гэдэг зэлгий зутан шиг нялцгар биетэй байдаггүй тул барьж тэмтчих юмгүй. Тэр нь тархин доторх ой санамжийг бүрдүүлэхгүй, цонхны гадна талаар дайрч өнгөрөхөөс цаашгүй.**

- ⑨ 俺もふつつかながら、この世界で二十年ご飯を食ってきた。

**Миний бие уран бүтээлийн ертөнцөд 20 гаруй жил хоол хороолоо.**

Эх зохиолд дүрслэн гаргасан зүйрлэл, адилтгал зэргээр үндэсний соёл сэтгэлгээг илэрхийлсэн дараах жишээг авч үзье. Орчуулгад сайн ч муу ч гэсэн утга бүхий хэллэгийг “байнд ч банзанд нь ч ойртохгүй” хэмээх утгаар төлөөлүүлсэн бол эх зохиолд “савх ч саваа ч биш” гэсэн үг хэллэг хэрэглэсэн байна. Энэ нь тухайн ард түмний амьдрал ахуйд хамгийн ойр зүйлээр аливаа зүйлийг төлөөлүүлэн зүйрлэн адилтгах, өвөрмөц утга илэрхийлэхтэй холбоотой аж.

- ⑩ 比較的良く書けた作品もあれば、箸も棒にもかからないものももちろんあとの方が圧倒的に多いんだけど--- ありました。

**Яах вэ харьцангуй сайн бүтээл ч ирэх л юм, байнд нь банзанд нь ч ойртохгүй бүтээл илүү олон байлаа л даа.**

Хэл яриа, нутгийн аялга зэргээс болж гадуурхагдах, доог тохуу болох, эсвэл тэр нутгийн хүн гэдгээ бусдад мэдэгдмээргүй байх хандлага аль ч улс оронд ажиглагддаг. Гэхдээ хүн төрж өссөн нутаг ус, хэлд орсон аялга зэргээс хэн нэгний өмнө ялгаварлан гадуурхагдах, эс бөгөөс өөрийн гарал харьяаллаас ичиж зовох зэрэг нь нийгмийн нэг сөрөг үзэгдэл юм. Үүнийг хичнээн хичээж байгаа ч төрөлх аялга хэл ярианы хөг нь тухайн хүнийг өөрийг нь илтгэж буйг дараах жишээнээс харж болно.

- ⑪ とりわけ関西で生まれ育った人間が東京に出てきて無理に東京の言葉を使おうとしている時の、いかにもそぐわない落差。

**Ялангуяа Кансайд төрж өссөн хүн Токиод ирээд өөрийгөө албадан байж токио (төв) аялгаар ярих гэж оролдовч яагаад ч юм нэг л болж өгөхгүй байв.**

Бид япон хүнийг ажилч хичээнгүй, хөдөлмөрч, үнэнч шударга гэсэн нийтлэг ойлголттой байдаг. Эх зохиолд япон хүний энэхүү дотоод мөн чанарыг Тэнгогийн эцгийн дүрээр төлөөлүүлэн гаргажээ. Харин дараах жишээнээс үзэхэд ажил мэргэжлээ голохгүй, сэтгэл зүрхнээсээ ханддаг, хөдөлмөрч эгэл жирийн япон хүний төлөөлөл манай уншигчдын сэтгэлд бууж байгаа болов уу.

- ⑫ 天吾の父親は職務をきわめて熱心に果たした。社宅に入り、健康保険に加入することもできた。ほとんど使い捨てに近い一般の委託集金人の待遇とは雲泥の差がある。それは彼がその人生において巡り合った最大の幸運だった。

**Тэнгогийн эцэг ажил хөдөлмөртөө туйлын хичээнгүй ханддаг нэгэн байлаа. Компанийн байранд нүүн орж, эрүүл мэндийн даатгалд ч багтжээ. Бараг л ашиглаад хаядаг байсан гэхэд хилсдэхгүй жирийн гэрээт мөнгө хураагчийн хувь зохиолтой эрс тэс ялгаатай ажээ. Тэр явдал түүний амьдралдаа учирсан хамгийн том хувь заяа билээ.**

Ийнхүү Харүки Муракамигийн “1Q84 “ зохиолын нэгдүгээр дэвтэрт Япон хүний соёл сэтгэлгээг хэрхэн илэрхийлсэн тухай тодорхой жишээн дээр тулгуурлан утга зүйн талаас тайлбарлах оролдлого хийлээ. Цаашид цуврал зохиолуудыг орчуулан уншигчдын хүртээл болгохоос гадна орчуулга судлал, орчуулгын шүүмж, утга зүйн судалгааг улам эрч хүчтэй явуулах цаг үе иржээ гэдгийг эцэст нь тэмдэглэн хэлэх нь зүйтэй болов уу.

## Дүгнэлт

Орчуулгын төрөл зүйлүүд дотор уран зохиолын орчуулга нэн төвөгтэй, тааварлах аргагүй бэрхшээлтэй байдаг бөгөөд уран зохиолын эх нь хэдэн зуун жил амьдрах чадвартай ажээ. Хүн төрөлхтөн өнгөрсөн зууны алдарт бүтээл, уран зохиол руу эргэн хандаж сэтгэл санаа, оюуны таашаал авсаар хэдэн мянган жилийг үдэхэд уран зохиолын орчуулга багагүй үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж болно. Мөн уран зохиолын орчуулга хийх үед орчуулж буй хэлний хэлзүйн бүтэц, үг хэллэгийн өвөрмөц нарийн онцлог, бичгийн хэлний хэм хэмжээ, найруулга зэрэг хэлний бүхий л онцлогт тохируулан буулгах ба орчуулагч нь өөрийн орны төдийгүй мөн тухайн эх зохиолд дүрслэгдэж буй орны түүх, соёл, шашин шүтлэг, зан заншил, ахуй амьдралын тухай сайтар судалж, мэдэх хэрэгцээ шаардлага гарч ирнэ.

Энэхүү өгүүлэлд уран зохиолын орчуулгаар дамжуулан япон хүний сэтгэлгээ, ахуй амьдралын хэв маяг, хүний дотоод мөн чанар, нийгмийн харилцаа ба хувь хүн зэрэг утгын хүрээнд эх зохиол ба орчуулгын зохиолыг утга зүйн талаас нь харьцуулан авч үзсэнээр дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

*Нэгдүгээрт:* Эх зохиолын үндсэн текстийн агуулгыг бүрэн дүүрэн гаргах үүднээс үндэсний онцлогийг илэрхийлсэн үг, өвөрмөц хэллэг зэргийг ойлгомжтой зөв оноон орчуулах

*Хоёрдугаарт:* Уран зохиолын хэрэглүүр, метафор, зүйрлэл, төлөөлөл, ихэсгэл, багасгал зэрэг аргуудыг зүй зохистой хэрэглэх

*Гуравдугаарт:* Экспрессив, конататив болон тухайн соёлд илрэх бэлгэдэл зүй, зохиогчийн хэл найруулгыг хадгалан утга санааг буулгах

*Дөрөвдүгээрт:* Эх зохиолын утга төдийгүй прагматик утгыг мөн адил бүрэн дүүрэн буулгах

*Тавдугаарт:* Эх зохиолд гарч буй хуучин үг хэллэг, нутгийн аялгууны үг хэллэг, этгээд бүдүүлэг үг хэллэг, хар ярианы үг, гадаад үг, утга зохиолын хэлний идэвхгүй үгс зэргийн үгсийн сангийн онцлог талуудыг анхаарах

*Зургаадугаарт:* Уран зохиолын найруулга түүний онцлог, утга шилжүүлэх яруу хэрэглүүр зэргийг орчуулахдаа тухайн ард түмний сэтгэлгээ соёлын онцлог, үндэсний уламжлал зэргийг харгалзан үзэх

*Долоодугаарт:* Зохиолын гол дүр, үйл явдлыг хам бичвэрээс салган ганц нэгээр үгчлэн орчуулах бус бүхэл бүтэн хэллэг, өгүүлбэр, нийт зохиолын зангидмал санаа, агуулга найруулгын ур чадварыг харгалзан бүтээлч сэтгэлгээгээр орчуулгад хандах

## Ном зүй

1. Мандах Д. (2010) Япон уран зохиолыг монгол хэлнээ орчуулсан туршлага, зарим шинэлэг тал, УБ. Бемби сан
2. Мүнэюки М, Баттогтох Р (2008) Японыг ойлгож монголд буулгах нь, УБ. МУИС-ийн хэвлэх үйлдвэр
3. Харүки Мүраками (2014) 1Q84, УБ. Монсудар хэвлэлийн газар
4. Haruki Murakami (2009) 1Q84, 新潮社